



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/17

Ховд

Эзэмшил газрын хэмжээ, талбай  
өөрчлөх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоол, 2016 оны 55 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Буянт багийн нутаг дэвсгэр Эко 1 дүгээр гудамжны 136 тоотод байрлах Далайн Оюунаагийн /ОТ76120566/ 400 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 764 метр квадрат, Цэцэрлэгт хүрээлэнгийн 1 дүгээр гудамжны 170 тоот болгон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 12 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Жаргалан багийн нутаг 1 дүгээр гудамжны 27 тоотод орших Баядбаатарын Нацагийн /ПЮ44020313/ 400 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 664 метр квадрат, Залуус-3 дугаар гудамжны 301 тоот болгон үйлчилгээний зориулалтаар 6 жилийн хугацаагаар өөрчлөн эзэмшүүлсүгэй

3. Газрын хэмжээ талбай өөрчлөгдөж байгаа дээрх аж ахуй нэгжэд газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 00075 Zax A/17.Ch